

**“ЭР БОР ХАРЦАГА” ХЭМЭЭХ УРТЫН ДУУНЫ
“ЖИГҮҮРХЭНДЭЭ” ХЭМЭЭХ ҮГИЙН ТУХАЙД ...**

Д. Баасанбат *

Монгол ардын уртын дуу “Эр бор харцага”-ыг өнөөгийн монголчууд ихэвчлэн :

Эр бор харцага нь **жигүүрхэндээ** хүчтэй

Идэр залуу насандаа даан ч ажиг үгүй явлаа... гэж дуулах ажээ. Монгол нутаг уудам, монгол хэлний нутгийн аялгуу өөр өөр байдгаас газар газар бас бага багахан хувилбартай дуулах юм.

Эр бор харцага нь **шигүүргэндээ** хүчтэй

Идэр залуу насандаа даан ч ажиг үгүй явлаа....

Эр бор харцага нь **жишүүхэндээ** хүчтэй

Идэр залуу насандаа даан ч ажиг үгүй явлаа....

Эр бор харцага нь **иш шүүхэндээ** хүчтэй

Идэр залуу насандаа даан ч ажиг үгүй явлаа....

Эр бор харцага нь **жиш шүүхэндээ** хүчтэй

Идэр залуу насандаа даан ч ажиг үгүй явлаа....

Эр харцага нь **шигүүргэндээ** хүчтэй шүү

Идэрхэн залуу насандаа даан ч ажиггүй явна даа...

Эр бор харцага **шигүүрхэндээ** хүчтэй л байна уу даа

Идэр залуу насанд нь даанч ажигч үгүй явлаа л бил үү дээ зээ...

Зээ, Эр бор харцага нь **жигүүрхэн** дээгүүр дэвнэ хө

Энэ идэр насандаа ажиг нь үгүй явлаа даа...

гэх мэтээр олон хувилбараар дуулж байна бас бичсэн байх юм. Үүнээс үзэхэд, энэ нь хүний тухай дуу юм уу, шувууны тухай дуу юм уу гэсэн эргэлзээг төрүүлж буй тул домогт юу өгүүлснийг сөхөн үзье.

Монгол домгийн чуулганд, Түшээт ханы Дайчин бэйсийн хошуунд Тэнгэр тэтгэсний тавиад оны үед ядуу эмэгтэй Арслан гэгчийн ганц хүү Харцага гэж бяра тэнхээ ихтэй, хүдэр том нэгэн хошуу нутагтаа барилдаж эхэлснээс хойш наадам болгонд түрүүлж түүнтэй эн зэрэгцэх сайн бөх үгүй ч харин туйлын ядуу зүдүү амьдралтайн эрхээр гуйлга гуйх, хулгай хийх зэргээр амьдарч байгаад хошуу ноёндоо гомдож явсаар эд хогшлоо баглан үүрч ээжийгээ дээр нь суулгаад баруун хойд зүгийг чиглэн явахдаа нэгэн дуу зохион аялан явсан нь эдүгээ монгол хүний хийморийг

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Монгол хэлний тэнхим

сэргээж найр наадмын сүлд дуулал болон уянгалж байдаг “Эр бор харцага” хэмээх дуу юм гэнэ.

Туульч, хөөмийч Д.Баасанжавын ярианд, Говь нутагт Найданжав гэдэг баян айл байжээ. Тэдний хаяа дагаж хар бор ажлыг нь хийдэг ядуу эмэгтэй Арслангаас арван сараа гүйцээсэн сайхан хүү төрсөнд, баян эзэн, манай авгайгаас нойтон сормуустай юм унаагүй байхад хань ижилгүй ганц бие бүсгүйгээс ийм сайхан хүү төрөх гэж, надад эдийн буян байлаа ч үрийн буян байсангүйдээ гэж бодлогоширдог болсныг мэдсэн эхнэр нь, хоёулаа өргөөд авчихъя, зарим нэг нь зарцаасаа авлаа гэж муу хэлнэ л биз. Арслан багаасаа л манай манай цагааг уулаа хөөрхий. Амны хишиг нь байгаа бол энэ хүү бид хоёрын буяныг хүртэх ч юм билүү? гэхэд зөвшөөрчээ. Хүрээ орж багш ламдаа үзүүлбэл “Буян заяанд чинь сэв суулгаж мэдэх бусдын хилэнг хөдөлгөж буяныг чинь барж мэдэх хүү байна, байгаа газраа барцад ихтэй баруун хойшоо хүн дагаж явах болов уу, үйл заяа хоёр нь тэгш биш, үргэлж нэр нь гарч мэдэх адармаатай золиг байна., өөрсдөө мэддээ “ гэжээ. Баян, “Тэгнэ ээ тэр. Арслангаас ариун юм яаж гарах вэ? Ад шулам гэдэг нь мөн боллоо.” гэж хэлээд санд мэнд үүр шөнөөр таван хар ямаатай нь орхиод нүүжээ. Тэрнээс хойш муу үг модон улаатай гэгчээр цуурхал яриа айлаас айл дамжин дамжсаар хавийнхан нь нүүжээ. Нэгэн өдөр босоо ороолон болсон хүүг жинсрэг цутгаж амьдаар нь газар булж дарах хүмүүс ирэх гэж байгааг дуулсан эх нь хүүгээ хөтлөн жинчид дээр очин зовлон жаргалаа ярихад ахлагч нь би олон охин хүүхэдтэй хүн, надад өгчих хэн нэгэнд нь хань болбол аштай юу гэжээ. Аянчид өнжиж хоноод явахдаа идэшний хэдэн хонь ямаа, номхон морь нэгийг өгөөд нутаг усаа зааж зурж өгөөд явахдаа хүүгийн нэрийг асуухад самгардаад Хур харцага гэж хэлжээ. Тэрнээс хойш нэг хэсэгтээ “Улаан уул”-ын өвөлжөө хавиар оторчин, жинчин гуйлгачин, түүлгэчин үзэгдэх нь ховор хэдэн жилд Арслангаас бас нэг хүү төрсөн нь мөн л бие бялдар сайтай хүү тул Эрхарцага гэдэг нэр өгчээ. Хүү 17 орчим насандаа хошууны наадамд шөвгөрч хойтон жил нь ноёны бөхийг хаяж ихэс дээдсийг хилэгнүүлснээс болж барилдах эрхийг нь хорьжээ. Түүгээр ч барахгүй нутгаасаа хөөгджээ. Эр харцага эр хүний уужуу тайван ухаанаар ноёндоо ”Би хошуу нутгаасаа явах боллоо. Манай хошуунд бөхийн удам бүү тасраасай гэсэндээ зодог шуудгаа танд өгүүллээ“ гэсэнд ноён ихэд уурлаж”чиний баастай зодог шуудгаар би яах юм бэ? Бушуухан хөөж зайлуул” гэж элч тахарт сөргүүлэн хэлжээ. Ихэд гомдсон эр харцага гэрээ үүрч дээр нь ээжийгээ суулгаад ах Хур харцагыг өргөж авсан хүнийг сураглан тэр зүг чиглэн явахдаа анх ингэж дуулжээ.

Эдгээр домгоос үзвэл, говь нутгаас гаралтай нэгэн бөх хүний үйл амьдралаас сэдэвлэсэн домогт дуу бололтой. Энэ тухай эрдэмтдийн судалгаа ч байна.

Академич Х.Сампилдэндэвийн “Монгол домгийн чуулган” түүвэрт:

Эр харцага нь **шигүүргэндээ** хүчтэй шүү

Идэрхэн залуу насандаа даан ч ажимгүй явна даа

Аяа хөөрхий алдрай мину зээ... гэж дуулж явах замдаа ноёны олон адуу мал усалдаг худгийн амыг тэртээ уулнаас чулуу үүрч ирээд тагласныг яаж ч оролдоод гаргаж чадсангүй дарагдсан гэдэг.

Цааш явахдаа: Арслангийн хоёр зулзага нь хө

Агуйдаа эргэлдэнэ дээ хө

Амрагийн сэтгэл нь

Хоёр биендээ жигүүртэй шүү ...гэж дуулан гуньж гутран явахдаа зодог шуудгаараа газар савсан (Савлага гэдэг уул одоо ч бий) гэдэг. Ингэж гомдож бухимдаж явахдаа Ноёны худгийг дарснаар ноёнд биш доорд ардад гай зовлон авчирч, олон мал сүрэг хүн зоны ус ундыг тасаллаа гэж гэмшин нэгэн газар хоноглохдоо шөнөдөө хад чулууг хаман улаан гараараа ундарга сайтай ус гаргасан нь анхандаа “Сайн эрийн ус” нэртэй байснаа “Сайншанд” болсон гэдэг.

Сайр шандын усыг шавхаж яаж барах вэ

Сайхан төрсөн хүний үрийг доромжилж яаж барна вэ

Аяа хөөрхий алдрай мину зээ

Хажуу газрын ногоо нь халиуран найгаад хүрэгтэнэ

Харьшгүй хүчтэй хүнийг хавчиж юундаа хөөнө вэ?

Аяа хөөрхий алдрай мину зээ... гэж дуулан хэрэн хэдэрч явахад нь, ахыг нь өргөж авсан хүн сургийг дуулаад, хөсөг унаагаар угтан тосч гэр орон төхөөрч мал сүрэг тасдан өгсөн гэдэг. Түүнээс хойш Эр харцага, Хур харцага хоёр наадам бүхэнд түрүүлж байсан гэдэг. Үүнээс үүсэлтэй ч юм уу бөхийн удам баруун хойд талдаа гарсан гэдэг домог бий. “Эр бор харцага” уртын дууг баруун аймгийн аялгуугаар дуулагдаж ирсэн нь энэ бөлгөө.

Уртын дууч Дорждагвын эмхтгэсэн “Уртын дуу”-ны түүвэрт:

“Эр бор харцага **шигүүрхэндээ** хүчтэй л байна уу даа

Идэр залуу насанд нь даанч ажигч үгүй явлаа л бил үү дээ зээ

Аяа хөөрхий алдрай мину зээ

Арслангийн маань зулзага ууландаа хүчтэй бил үү дээ

Амрагийн хоёр сэтгэл аль алиндаан асрамжтай билүү дээ

Аяа хөөрхий алдрай мину зээ

Сайр шандын усыг шавхавч бардаггүй бил үү дээ

Сайн хүний үрийг даравч болдоггүй бил үү дээ

Аяа хөөрхий алдрай мину зээ

Хажуу талын ногоо нь халиурч найгаад ганхана бил үүдээ

Хамаг та бүгдтэйгээ

Ханатлаа найрлах жаргалтай бил үү дээ.

Аяа хөөрхий алдрай мину зээ”

Академич Д.Цэрэнсодномын МААЗ-ын тайлбар дээж бичигт:

“Зээ, Эр бор харцага нь **жигүүрхэн** дээгүүр дэвнэ хө

Энэ идэр насандаа ажиг нь үгүй явлаа даа

Аяа алдрай мину зээ.

Арслангийн зулзага ану агулан думдаа эрэгтэй

Амраг сайхан тэр мину манд юундаа эрхтэй

Аяа алдрай мину зээ.

Үе бага насандаа улам энд хөгжилдөөд

Үнэн бат сэтгэлээ үзэлцэж таних

Аяа алдрай мину зээ.

Амь биеийн адил амраг янаг таныгаа

Зүрхэндээ санаж алмайрч ядвай

Аяа алдрай мину зээ.

Сэв нь үгүй гүйдэлтэй торниун борыгоо унаж
Сэтгэл дороо нийцсэн нөхөдтэйгээ золгоё
Ая алдрай мину зээ.
Хажуу талын ногоо нь халиуран ганхаж ургана
Хамт л сагугсан таныгаа хөгжөөн болгож дуулвай
Ая алдрай мину зээ.
Эрдэнэсийн адисаар энд хамт учраад
Ерөөл юугаа талбиж эгүрд бат болтугай
Ая алдрай мину зээ”.

Монгол улсын төрийн шагналт, эрдэмтэн Ц.Шагдарсүрэн:

“Шүүргэ буюу монгол бичгийн хэлнээ шигүүргэ гэдэг үг жигүүр болсон нь монгол хэлнээ шуур- шуурга, төөр-төөргө, хуур- хуурга, нөмөр- нөмөргө, гэх мэтээр үйл үгээс нэр үг үүсгэдэг

“-га” дагавар байдаг бөгөөд энэ нь тухайн үйлийн үр дүнд буй болсон зүйлийг нэрлэдэг бөлгөө. Шүүргэ гэдэг нь шүүрэх чадвар гэсэн утга илэрхийлдэг байна. Уг үгийн энэ утгыг ухаарахаа больсны харгайгаар шувуутай холбоотой юм болохоороо “жигүүр” л байж таарна гээд мөнөөх үгийг жигүүр болгон “зассан” хэрэг. Чухамдаа харцагаас хүчтэй бөгөөд том жигүүртэй шувуу ч мундахгүй олон бийг бас л анзаараагүй ажээ.

Монгол бөөгийн дуудлага болон “бууны сангийн судар” тэргүүтэнд”...луугийн дуутай, гарьдын шүүргэтэй гэсэн үг бишгүй гардаг билээ. Энэ мөнөөх “шүүрэх чадвар”-ыг нь хэлж байгаа бөгөөд хэрэвзээ мөнөөх мэдэмхийрэн засагчид үзсэн бол “...луугийн дуутай, гарьдын жигүүртэй...” болгох байсан буй за.. дээрх “бууны сан “дах *шигүүргэ* үгийг монголч эрдэмтэн Ч.Бауден англиар “claws” гэдэг үгээр орчуулсан байдаг нь ямар ч атугай шувууны жигүүртэй биш, харин сарвууны холбож ойлгосон нь тодорхой. Хэрэвзээ “шүүрэх чадвар” хэмээн үзэх бөгөөс англи нэг үгээр оноох боломжгүй бол ядахдаа “the act of snatching or the capture with claws (on the bird of prey)” гэж тайлбар маягаар зүүсэн бол бүр ч илүү ойртох байсан буй заа”.

Эдгээрийг харгалдуулан уншихад дууны гол утга нь шувууны тухай биш хүний тухай болох нь тодорхой болж байна. Хэрэв тийм бол энэ дууны үг **жигүүрхэндээ** байж болох уу?

Монгол улсын даяар дуурсагдах далай даян дархан аварга Хорлоогийн Баянмөнхийн, Эрт цагт Эр харцага, Бор харцага гэсэн нэртэй ах дүү хоёр хүчтэй бөх байсан. Тэдний “**иш шүү**” гээд дайрах нь даанч хүчтэй хэр баргийн юм тогтоох аргагүй байсан тухай домог байдаг. Нээрээ л бөх хүн чинь нөгөө бөхийнхөө өөдөөс “**иш шүү**” гээд лдайрч ороод л барьж авах юм уу, хав золгох, эсвэл шороо цацаад л, бас алга хавсраад л ухасхийдэг биз дээ. Энэ үед л бөхийн амнаас гарч байгаа дуу нь ийм л авиа сонстдог шүү дээ. Тиймээс “Эр бор харцага” дууны үгэнд:

Эр бор харцага нь **иш шүүхэн** дээ хүчтэй

Идэр залуу насандаа даанч ажрахгүй явлаа... гэж гардаг юм. Энэ бол Шувууны тухай дуу биш бөхийн тухай дуу гэж телевизээр хэд хэдэн удаа ярьж байхыг нь сонссон билээ.

Үнэхээр монгол бөх, монгол хүчтэнүүд **иш шүү** гээд л ухасхийн бариад авбал юуг ч тэсгээхгүй, дийлэхээр их хүч, зориг нэмэгддэг, харин **жишүүхэн** харц тулахаас халгаа л байгаа бол цочоотой цалгиатай, бариа зөрөөндөө гартаа хүчтэй тэнхээтэй байдаг.

Шүүрэх гэдэг үг Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт:

1. Юмыг бусдаас урьтаж, цочмог, түргэн булаан авах:

шүүрэн авах) - *Санаашран бодовч эгцлэн харсангүй, нүцгэн биеэ халхлахыг яаран тэрлэгээ санд мэнд шүүрэн авч хөдрөв. Б.Чойндон. Галбын говьд.*,

шүүрэн барих (түргэн барьж авах) - *Миний айдас хүрч ухарсанд, тэр ухасхийн мөрөн дээрээс шүүрэн барилаа. Д.Маам. Тэмээний дууль.*,

-тавхийн барьж шалмаг татан авах, \жигүүртний шумбан дайрч шүүрэн савардан авах\,

гараас нь шүүрэх (гараас нь түргэн барьж авах);

2. Элээ, бүргэд зэргийн жижиг амьтан болон юмыг базаж самардан авах:

бүргэд шүүрэх (бүргэд юм базаж самардан авах),

элээ **шүүрэх** (элээ юм базаж самардан авах) - *Хан гарьд шувуу унагыг шүүрчээ, дэрсэн нум сумаар харватал, нэг юм ойчжээ. Халх ардын тууль;*

3. Юмыг гараар самардан авах:

чулуу шүүрэх (чулууг гараар самардан авах) - *Суух гээд чулуу шүүрэх. Ж.Дашдорж. Монгол цэцэн үгийн далай.*,

шагай шүүрэх (шагайг гараар базаж самардан авах);

4. *шилжсэн* Юманд шүргэх, ойртох, хүрэх төдий болох:

өвсөн толгой шүүрэх (морь, мал өвсний толгойг явуут дундаа зулгаах) - *Амгайвчтай байхдаа ус шимэн ууж, аяар сажлахдаа өвсөн толгой шүүрч, номхон хул дөрвөн цагт, ноолгор тохомтой янгиа эмээлтэй байв. Б.Жамд. Сэтгэлийн нууц.*,

өндөр өвс дөрөө шүүрэх (өндөр ургасан өвс, дөрөө шүргэх, хүрэх), -унжсан дүүжлэгдсэн юм доош юманд тулж шүргэх, \дөрөө шүүрэм бэлчээр\

оройн нар, уулын толгой шүүрэх (оройн шингэж буй нар, уулын толгойд ойртох, хүрэх мэт болох);

5. *шилжсэн* Наслах - *Дөнгөж гуч шүүрч яваа болов уу гэмээр цэл залуу хүн байв. С.Лочин нар. Галтай залуу нас.*

6. Савтай шингэн зүйлийн гадагш нэвчин гарах, гоожих:

аарцны шар ус шүүрэх (аарцны шар ус савнаас гадагш нэвчин гарах),

ус шүүрэх (ус савнаас гадагш нэвчин гарах),

шүүрэх шиврэх хоршоо (шингэн зүйл ганц хоёр дуслар удаан гоожих);

7. Амьтан, ургамлын биеэс ямар нэгэн шингэн зүйл ялгаран гарах:

цус шүүрэх (цус ялгаран гарах), - юмны шүүс алгуур ялгаран шавхрах,

-амьд бодисын эс, эрхтнээс юмар нэгэн шингэн зүйл гарах,

жимсний шүүс шүүрэх (жимсний шүүс ялгаран гарах);

8. Газрын дороос ус зэрэг шингэн юмны дааварлах, нэвчих:

ус шүүрэх (газрын гүнээс ус дааварлан нэвчих) - *Удаан бэхэлгээний бетонон хананаас хөлс дааварлахуйн адилаар ус шүүрч, шагай өнгөрсөн шалбааг үе үе хөл дор дайралдана. С.Лочин. Сэтгэлийн өнгө.*

9. Чоно, нохойн амьтанд ноцож хальт зууж авах .. гэх мэт.

Дээрх тайлбараас ажиглавал монгол хэлэнд **шүүрэх** гэдэг үг олон салаа утга хадгалдгаас мөнөөх дуунд өгүүлж байгаа нь хамгийн гол нэгдүгээр утгыг хадгалж байгаа гэж бодож байна. Энэ нь дууны утга агуулгаас ч тодорхой юм.

Эр бяраа гайхуулсан эрч хүчтэй, булчин шөрмөс нь зангирсан сайхан эрчүүд чинь сарвуундаа, бугуйндаа, шуундаа, эгэмдээ, мөрөндөө, гартаа, цээжиндээ, гол ясандаа, бөгсөндөө, шилбэндээ, шаандаа, өлмийдөө, өсгийндөө, бяртай байхаас гадна, атгах, чимхэх, шүүрэх, халах сэлэх, дугтрах, сугсрах, түрэх, түлхэх, цацах, цалгих, бусгах булгих, сэжихдээ мөргөхдөө их хүчтэй, мөн **иш шүүхэндээ, жиш шүүхэндээ > жишүүхэндээ** их хүч гаргадаг иртэйхэн, аатайхан үе ч бас байна аа.

Энэ бүхнээс үзвэл, домогт өгүүлснээр ах дүү хоёр Харцага хэдийгээр эртэй бяртай ч ядуу, ганц бие бүсгүйн хүүхэд тул ихэс дээдэст хавчигдан гадуурхагдаж, аргагүйн эрхэнд нутаг орноосоо явахдаа зохион дуулсан нь Монгол ардын аман зохиол, Монголын эртний уран зохиолд байдаг уламжлалт дүрслэл, санааг хадгалсан байна.

Тус дууны хувилбаруудад гарч буй **иш шүү, жиш шүү, жишүүхэндээ** (шигүүргэндээ) гэдэг үг нь хүчит бөхчүүдийн “аа, омгоо” гаргах хүч нэмсэн, авиа гаргаж илэрхийлсэн нь энэ.

Гартаа эгэмдээ, шуундаа, бугуйндаа, сарвуундаа хүчтэйн улмаас татах түлхэх, суйлах дугтрах, халах сэлэх, шүүрэх атгах нь халшрам, хэр баргийн хүн тэсч тогтохын аргагүй дэндүү хэтийдсэн хүчтэй байдгийг үзүүлсэн зэргээс, шувуу биш болох нь тодорхой байна. Гэтэл яагаад **жигүүр** болсон билээ гэвээс “харцага” гэдэг үгийн гол утга нь шувууны нэр учраас шууд л шувуу гэж ойлгосон ба уг дууны үүсэл, домгийг өмнө сонсоогүй, үл мэдэхтэй холбоотой учраас, **шигүүргэндээ**(sigurge degen-sigurgendegen) гэх үг монгол бичгийн болон эртхэний шиг дуудлага нь монгол хэлний нутгийн аялгуутан нарын дунд (sh~j,g~k) гийгүүлэгч сэлгэх нь элбэг тул **шигүүргэн** нь **жигүүрхэн** болж хувирсан ажээ. Иймээс ,

Эр харцага нь **жигүүргэндээ** хүчтэй

Идэрхэн залуу насандаа даан ч ажиггүй явлаа... гэж шувууны тухай дуулах биш

Эр харцага нь **шигүүргэндээ** хүчтэй шүү

Идэрхэн залуу насандаа даан ч ажиггүй явна даа... гэж эртэй бяртай бөхийн тухай магтан дуулах нь илүү нийцэлтэй ажгуу.

Эр бор харцага гэдэг, энэ сайхан дуу зуун зууныг дамжин хүний амьдралын утга учир болсон идэр залуу насны алдаа эндэлийг сануулсаар уламжлан ирсэн билээ.

Хэл бол түүхийн явцад хувирч өөрчлөгдөж байдаг амьд зүйл мөн боловч, ер нь ардын дуунд уул үгийнх нь утга болон дуудлагыг ташаа ухаарснаас солигдож өөрчлөгдсөн зүйл байдгийн нэг жишээ нь энэ дууны үг юм. Монгол ардын дуу нь соёлын үнэт өв учир үгийг нь уг анхныхаар нь хадгалан хэвшүүлбэл илүү зохистой ажээ.

НОМ ЗҮЙ

Ж.Дашдорж, *Монгол цэцэн үгийн далай*, Улаанбаатар, 1973.

Д.Цэрэнсодном, *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*, Улаанбаатар, 2012.

Монгол домгийн чуулган, Эмхтгэсэн Х.Сампилдэндэв. Улаанбаатар, 1999, 268-272-р тал.

Улаанбаатар сонин, 1998, №-52, 53. Д.Баасанжавын яриа

Уртын дуу, Эмхтгэсэн Ж.Дорждагва, Улаанбаатар, 1970.

Ц.Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан*, Улаанбаатар, 2007.

SUMMARY

In this story “Er bor khartsaga” Mongolian folk song’s above word is not different of relevant with person or with bird cause variety counties speak “shuurge, shiguurgendee, jiguurhendee, ish shuukhendee, jish shuukhendee, jishuukhendee” etc that’s why I want to assume indicting by spring of legend.